

ЯПОНЧУУД ГЭЖ ХЭН БЭ?

Ц.Онон *

Товч утга:

Э нэхүү өгүүлэлдээ япон хүний сэтгэлгээ, япон соёлын талаар 1948-2010 оны хооронд хэвлэгдсэн гадны болон японы судлаачдын гол судалгааны бүтээлийг авч үзэн, тэдгээрийн судалгааны үндсэн арга зүй, хүрсэн дүгнэлтийнх нь нийтлэг ба ялгаатай талыг тодруулахыг зорьсон болно. Ингээд өнөөг хүргэлх судалгааг арга зүйн талаас нь 1) харийн соёлтой харьцуулах аргаар япон соёлын байр суурийг тодорхойлохыг зорьсон, 2) бусад улс орны соёлыг өөртөө шингээн авсан арга замыг нь тайлбарлах аргаар япон соёл, япончуудын сэтгэлгээний онцлогийг тодруулахыг зорьсон, 3) гадны соёлын нөлөө харьцангуй бага туссан бүс нутгийн жишээгээр япончуудын соёл, сэтгэлгээний онцлогийг тодруулахыг зорьсон судалгаа хэмээн ангилан үзсэн бөгөөд дийлэнх судалгаанд япончуудыг дараах байдлаар нийтлэг дүгнэжээ гэж үзэж болохоор байна.

1. Өөрийгөө бодох гэсэн ойлголт тун сул, зөвхөн өөрийн хүчинд дулдуйдсан хувь хүн нийгэмд байр сууриа олоход хэцүү гэж ойлгож итгэдэг.
2. Харилцан зөвшилцөл, тэнцвэртэй байдал, нэг санаа гэсэн зарчмыг хатуу хэвшил болгон баримталдаг. Энэ нь нийгмийн тогтвортой байдал, нэгдмэл чанарыг хангахад гол тулгуур нь болдог.

Түлхүүр үг: япон хүн, япон соёл,

『日本人論』 буюу япончуудын соёл, сэтгэлгээ, япончууд гэж чухам ямар хүмүүс вэ? гэх үзэл бодол, төсөөлөл ойлголтын цогц нь Эдогийн үеийн* шашин номлогчдын нутаг руугаа бичиж илгээсэн сэтгэгдэл, далайн шуурга, давалгаанд туугдан Орос, Канадад очсон япон загасчид, хөлгийн ахмадуудын мэдээ сэлтээс эхтэй гэж үздэг. XIX зууны дундуур

*.Онон – Монгол Улсын их сургуулийн багш, доктор (Ph.D)

* 1600-1867 он хүртэлх үе

Японы шинэ засгийн газар тэргүүний сэхээтэн залуусыг баруун европын улсуудад зориуд илгээж эхэлсэн бөгөөд тэдний сэтгэгдэл, дурсамж, тайлан илтгэл, японыг зорин ирсэн гадны соёлын антропологич эрдэмтдийн ажиглалт тэмдэглэл, эссе нийтлэлүүдээс ч япон хүний сэтгэлгээ, соёлын онцлогийн талаар мэдэж болно гэдэг.

Хятад-Японы дайн, Орос-Японы дайн, мөн Дэлхийн нэгдүгээр дайнаас хойш гадаад ертөнцөд япончуудын тулалдах урлаг, дотоод сэтгэл, эх оронч үзлийн цаана чухам юу байна гэдэг нь судлаачдын сонирхлыг татах болж, түүнийг нь гэрчлэх Р.Бенедиктийн “Удвал цэцэг ба илд”, Е.Хэрригелийн “Нум ба зэн буддизм” зэрэг судалгааны бүтээл, эссе нийтлэл гарчээ. Соёлын антропологич Р.Бенедикт хүмүүсийн ажил үйл, зан аашийг ажиглан, улмаар юмыг сэрж тусгах, сэтгэж эргэцүүлэх арга ухаан, ёс зүйн онцлогийн талаар таамаг дэвшүүлэн, тодорхой баримтаар мөшгин, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргаар соёлын онцлогийг нь тайлбарлахыг зорьсон бөгөөд Үарууны соёл нь ёс суртахууны тухайн хэм хэмжээг зөрчвөл, “ял зэмлэл ноогдуулах” арга хандлагыг голчилдог бол япон соёл нь тухайн ёс суртахууны хэм хэмжээг аль болох зөрчихгүй байхыг урьдаас зорьж, зөрчвөл “ичгүүрт унах”-ыг жигшин сэрэмжлүүлсэн арга хандлагатай хэмээн тодорхойлсон түүний зохиолыг судлаачид япон хүн, япон судлалын сонгодог бүтээл хэмээн үнэлдэг.

Дэлхийн хоёрдугаар дайны дараах японы үсрэнгүй хөгжил ч гэсэн судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж, түүнийг өөр өөр тал, өөр өөр өнцгөөс үнэлж тайлбарласан ном зохиолууд, тэр дундаа япончуудыг “нэгдмэл, нэг хэвийн хүмүүсийн бүлгэмдэл хэмээн үзэж, өөр соёлтой харьцуулан, өөрийн гэсэн өвөрмөц, онцгой байдлыг нь тодруулан авч үзсэн бүтээлүүд олон гарах болсон байна.

Нийгэм, соёлын антропологийн судалгаанаас гадна, үндэсний үзэлд тулгуурлан, эх орон, үндэстний онцлогоо тодруулахыг зорьсон япончуудын онол, шүүмжийн бүтээл ч цөөнгүй байдгийн дотор япон хүний соёл, сэтгэлгээний талаар өнгөрсөн зуунд хэвлэгдэн гарсан судалгааг тоймлон, үнэлэлт дүгнэлт хийсэн “Олон улсын хамтын ажиллагааны эрин ба Япон хүн”, “Япон хүнийг үзэх үзэл 12 бүлэгт” хэмээх хоёр судалгааны бүтээлийг эрдэмтэд онцлон ишилж ашигладаг байна.

Түүнчлэн, Ш.Саэки, Т.Хага нар 1987 онд хэвлүүлсэн бүтээлдээ гадаадын зохиолч, соёл, урлаг судлаач, шүүмжлэгч 42 хүний япончуудын нийгэм соёл, сэтгэлгээний онцлогийн талаар сүүлийн 150 гаруй жилд бичиж хэвлүүлсэн бүтээлийг танилцуулж,

тэдгээрийн талаарх өөрсдийн эргэцүүлэл, санаа бодлоо тусгасан байна.

Япончуудыг өөр соёл, шашинт үндэстэнтэй харьцуулан авч үзсэн соёлын антропологийн харьцуулсан судалгааны эхлэлийг судлаач И.Бен-Дасан тавьсан бөгөөд тэрээр “Япон хүн ба еврей хүн” бүтээлдээ эв нэгдэл, байгаль орчноо дээдэлдэг япончуудын хувьд аюулгүй амар тайван байдал, ус хоёр үнэгүй байдаг нь гайхах зүйл биш хэмээн онцолсон байна. Түүний дараах томоохон судалгаанд Английн эрдэмтэн П.Миллвордын “Англичууд ба япончууд”, Солонгосын эрдэмтэн Ё.Кимийн “Солонгос хүн ба япон хүн-хоёрдмол соёлын олон талт чанар”, японы судлаач Ю.Шинолагийн “Япон хүн ба герман хүн-Бөхийх соёл ба гэдийх соёл”, Америкийн судлаач Р.Нисбетийн “Модыг нь хардаг барууныхан ба ойг нь хардаг япончууд” зэрэг зохиол зүй ёсоор ордог.

Японы түүхч, зохиолч Р.Шибба болон Америкийн судлаач Д.Кийн нарын япончуудын дайн тулааныг үзэх үзэл, ёс суртахуун, сэтгэлгээ, япон соёлын үүслийн талаарх “Япон хүн ба япон соёл”, Японы сэтгэл судлаач Дой Такэогийн япончуудын сэтгэл зүй, нийгмийн байгууллын талаарх “Амаэ-гийн зохион байгуулалт” зэрэг бүтээл өнөө хэр нэр хүндтэй судалгаанд тооцогддог агаад судлаач Т.Дой бүтээлдээ: “бусадтай нийцтэй, тэднээс харилцан хамааралтай байх гэсэн санаа бодол нь япон хүний өвөрмөц онцлог гэж үзээд, тэрхүү санаа бодол, сэтгэлгээг нь “Амаэ**” гэж тодорхойлон, түүгээр нь дамжуулан япон хүний сэтгэлгээ, японы нийгмийн онцлогийг тодорхойлон гаргахыг зорьсон нь бас л анхаарал татахуйц асуудлыг дэвшүүлсний баримт гэж үздэг.

Т.Аоки 1990 онд хэвлүүлсэн “「Япон соёлын онол」 -ын хувьсал-Дайны дараах япон соёл, түүний онцлог”, судлаач Т.Фүнахики “Япон хүний талаар дахин эргэцүүлэх нь” (2003), Токиогийн Их Сургуулийн профессор Ч.Наканэгийн “Гэр бүлтөвтэй хүмүүний харилцаа” (1977) бүтээлүүд нь япон хүн, тэдний соёл, сэтгэлгээний онцлогийг уламжлал шинэчлэлийн зааг, үргэлжлэлийн мөчлөгт нь авч үзсэнээрээ мөн л сонирхол татдаг.

Япон хүний сэтгэлгээ, япон соёлын талаар 2010 он хүртэл гарсан онолын нийт судалгааг ерөнхийд нь

- Харийн соёлтой харьцуулах аргаар япон соёлын байр

** 「甘え」 -угчлэн орчуулбал, зөөлчлөх, эрхлэх, чихэрлэг гэсэн утгатай

суурийг тодорхойлохыг зорьсон судалгаа;

• Энэтхэг, Хятад, Голланд гэх мэт тухайн цаг үеийнхээ соёлын гол төв болж байсан улс орны соёлыг өөртөө шингээн авсан арга замыг нь тайлбарлах аргаар япон соёл, япончуудын сэтгэлгээний онцлогийг тодруулахыг зорьсон судалгаа;

• Гадны соёлын нөлөө харьцангуй бага туссан бүс нутгийн жишээгээр япончуудын соёл, сэтгэлгээний онцлогийг тодруулахыг зорьсон судалгаа хэмээн ангилан үзэж болохоор байгаа бөгөөд дийлэнх судалгаанд япончуудыг дараах байдлаар нийтлэг дүгнэжээ гэж үзэж болохоор байна.

3. Сэтгэл зүйн үүднээс үзвэл, өөрийгөө бодох гэсэн ойлголт тун сул, зөвхөн өөрийн хүчинд дулдуйдсан хувь хүн нийгэмд байр сууриа олоход хэцүү гэж ойлгож итгэдэг.

4. Харилцааны талаас үзвэл, тэд ямагт нийтгэч байдлыг эрхэмлэн, аливааг хамтдаа хийх гэсэн тэмүүлэлтэй бөгөөд өөрийн харьяалагдах бүлэг, хамт олныхоо дунд идэвх санаачлагатай байж, хувь нэмрээ оруулахаар зүтгэх нь япон хүний онцлог зан чанар болдог. Нийгмийн түвшинд үзвэл, харилцан зөвшилчил, тэнцвэртэй байдал, нэг санаа гэсэн зарчмыг хатуу хэвшил болгон баримталдаг. Энэ нь нийгмийн тогтвортой байдал, нэгдмэл чанарыг хангахад гол тулгуур нь болдог.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Э.Намжим, “Япон орон тоймлон харвал”, Уб., 1999
2. 『日本人論—国際協調時代にそなえて』野村総合研究所、1978
3. 杉本良夫、ロス・マオア共編著『日本人論に関する12章』ちくま学芸文庫、1982
4. 佐伯彰一、芳賀徹『外国人による日本論の名著—ゴンチャロフからバングまで』中公新書、1987
5. イザヤ・ベンダサン、山本七平訳『日本人とユダヤ人』文藝春秋、1970
6. 金容雲『韓国人と日本人 双対文化のプリズム』サイマル出版会、1983
7. 篠田雄次郎『日本人とドイツ人 猫背の文化と胸を張る文化』光文社、1997
8. Richard E. Nisbett『木を見る西洋人 森を見る東洋人』ダイヤモンド社、2004
9. 司馬遼太郎、ドナルド・キーン『日本人と日本文化』中公新書、1972

10. 土居健郎『「甘え」の構造』、1973
11. 青木保『「日本文化論」の変容—戦後日本の文化とアイデンティティー』中公文庫、1990
12. 船曳建夫『「日本人論」再考』日本放送出版協会、2003
13. 中根千枝『家族を中心とした人間関係』講談社学術文庫、1977

Abstract

Theory about the Japanese is a genre of texts that focus on issues of Japanese national and cultural identity by Japanese and by foreign scholars, journalists, and residents.

The concept became popular after World War II, initially including books and articles aiming to analyze, explain, or explore peculiarities of Japanese culture and mentality, usually by comparison with those of Europe and Western culture. Such texts share a general vision of what constitutes the uniqueness of Japan. Scholars commonly contribute to perspectives characteristic of the Japanese genre as follows:

- Japanese psychology is defined by a particular cast of dependency wishes or desires that conduce to a unique form of human relationship.

- Japanese social structures consistently remould human associations in terms of an archaic family or household model characterized by vertical relations. As a result, the individual cannot properly exist, since group will always prevail.

Keywords: Japanese, Japanese culture